

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2023 оны санхүүгийн тайлангийн хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/16/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.11 № 112

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говь-Алтай аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Говь-Алтай аймаг дахь Радио телевизийн сүлжээний газар нь 2023 оноос Цахим хөгжил, Харилцаа холбооны Яаманд харъяалагдах болсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,500.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 12,262.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 19,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан борлуулж данснаас хассан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилт, 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Радио Телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702900367

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	193,895.8	190,477.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,200,731.3	10,869,699.4
Нийт хөрөнгийн дүн	11,394,627.2	11,060,177.1
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,394,627.2	11,060,177.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,394,627.2	11,060,177.1
Үйл ажиллагааны орлогын дүн	1,131,382.8	391,795.9
Үйл ажиллагааны зардлын дүн	436,344.6	726,246.0
Үйл ажиллагааны үр дүн	695,038.2	(334,450.1)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	695,038.2	(334,450.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,699,740.3	11,394,627.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Тайлант оны үр дүн	694,886.8	(334,450.1)
Эцсийн үлдэгдэл	11,394,627.2	11,060,177.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	255,836.7	360,688.4
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	252,839.1	356,299.3
Үйл ажиллагааны ЦМГ	2,997.6	4,389.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(2,500.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	2,997.6	1,889.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	682,725.0	3,680.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	685,722.6	3,682.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	252,839.1	358,799.3
Урсгал зардал	252,839.1	358,799.3
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	255,836.7	360,688.4
Улсын төсвөөс санхүүжих	252,834.4	356,816.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3,002.3	3,872.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3 зөрчил¹ илэрч 1 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Ажлаас чөлөөлөгдсөн 4 ажилтанд амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлтйг 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн шийдвэрийг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж байх албан шаардлага хүргүүлсэн .

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймаг дахь Радио телевизийн сүлжээний газар	1	-	-	-	-	-	1	-	-	-
Нийт	1	-	-	-	-	-	1	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймаг дахь Радио	1	-	-	-	-	-	1	-	-	-



Говь-Алтай аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

телевизийн сүлжээний газар	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 1,945.1 мянган төгрөгийн 14, зарлагын 96,320.9 төгрөгийн 7 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 54,523.0 мянган төгрөгийн 11 шийдвэрийг тус тус мэдээлээгүй.	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-